



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар A/132

Батноров сум

Өмчлөлийн газрын хэмжээ өөрчлөх тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дахь заалт, Монгол улсын Хаягжуулалтын тухай хуулийн 4.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах тухай" журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.2009 оноос геодезийн байрлал, өндрийн нэгдсэн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор туузан метрээр хэмжиж тодорхойлсон, кадастрын зурагт тэмдэглэгдсэн байршил, газрын талбайн хэмжээ нь нарийвчилсан хэмжилтээр зөрүүтэй гарах тохиолдлууд гарч байгаатай холбогдуулан иргэн Пүрэв-Очир овогтой Ариунгэрэлд гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Салхит гудамжны 103 тоот хаягт байрлалтай 1383200 (Нэг сая гурван зуун наян гурван мянга хоёр зуун) төгрөгийн үнэ бүхий 988 м² газрыг өмчлүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Батноров сумын Засаг даргын 2018 оны А/06 тоот захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгч П.Ариунгэрэлд өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОТГОНБАЯР



230531054